

## Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2015 оны 4 дүгээр сарын байдлаар)

### I. Нийгмийн үзүүлэлт




#### I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2015 оны 4-р сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 743 болж, 2014 оны мөн үеэс 123 хүнээр, өмнөх сарынхаас 147 хүнээр тус тус өсөв.

Ажилгүйчүүдийн 48,05 хувь буюу 357 нь эмэгтэйчүүд юм. 2015 оны эхнээс 306 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 94 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 44,68 хувь буюу 42 нь эмэгтэйчүүд байв. Ажилгүйчүүдийн бүртгэлээс оны эхнээс 787 иргэн хасагдсан байна.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 4 дүгээр сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 140 ажилгүй иргэний 35,86 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 25,06 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 7,36 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 7,13 мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 6,67 хувь нь шилжин суурьшсан; 2,99 хувь нь орон тооны цомхтголд орсон; 2,99 хувь нь байгууллага татан буусан; 2,76 хувь нь

цэргээс халагдсан; 1,84 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 1,38 хувь нь одоо эрхэлж байгаа ажлаа солих хүсэлтэй; 1,15 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 0,23 хувь нь хорих газраас суллагдсан; 0,23 хувь нь тэтгэвэрт гарсан; 4,37 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ. Ажилгүйчүүдийг боловсролын түвшнөөр хуваавал 18,30% нь дээд; 5,65% нь тусгай дунд; 10,63% нь мэргэжлийн анхан шатны; 54,64% нь бүрэн дунд; 7,40% нь бүрэн бус дунд боловсролтой; 2,42% нь бага; 0,94% нь боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2015 оны 4 дүгээр сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

\*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



#### I.2 Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 4 сард НДШ-ийн орлого 4.2 тэрбум ₮ болж төлөвлөгөө 78.60 хувь болж, төлөвлөгөөг бүх сум 1.53-57.17 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 67.2 сая ₮ болж төлөвлөгөөг бүх сум 15.86-27.98 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжид 11.6 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.2 хувийг өндөр настны, 10.5 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.9 хувийг тэжээгчээ алдсаны, 5.4 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 258080 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 28.96 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 20.25%; тэтгэмжийн даатгалын сангийн 99.18%; эрүүл мэндийн даатгалын сангийн 76.04%; үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 195.29%; ажилгүйдлийн даатгалын сангийн 114.91%-ийг тус бүр бүрдүүлжээ.

### Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 4 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 48846 хүнд олгож, 4.2 тэрбум₮-ийг зарцуулж 2014 оны мөн үеэс хүний тоо 40.25 хувь 32915 хүнээр буурч, зарцуулсан мөнгөний хэмжээ 2.64 хувь 109.0 сая₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 108380 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.4 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 22.1 хувийг халамжийн тэтгэвэр; 7.8 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 5.6 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 1.9 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 2.9 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.8 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




### 1.3 Эрүүл мэнд

2015 оны эхний 4 сард 5272 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 13.1 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 4 сард 402 хүүхэд мэндэлсэн нь 2014 оны мөн үеэс 54 хүүхдээр буурлаа.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар.




Аймгийн хэмжээнд 2015 оны 4 сарын байдлаар нялхсын эндэгдэл 5 гарч өмнөх оны мөн үеэс 2-оор өссөн байна.

5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд гараагүй байна.

Зураг 1.4

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар




2015 оны эхний 4 сард нийт гарсан халдварт өвчнөөр 209 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 19.4 хувь буюу 34 хүнээр өслөө. 2014 оны мөн үеэс, тэмбүү 87.5, сүрьеэ 22.8, салхин цэцэг 17.3

хувь, тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 23 байгаа бол: Зуунмод 74, Цээл 48, Борнуур 28, Сэргэлэн 27, Баянжаргалан 25 ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



I. Төв аймгийн 2015 оны 4 сарын цаг агаарын байдлыг олон жилийн дундажтай харьцуулсан тойм

2-нд зарим газраар 0,0 мм, 3,4-нд нийт нутгаар 2,4-19,0 мм, 10-нд ихэнх нутгаар 0,0-4,0 мм, 11-нд зарим газраар 0,0-3,0 мм, 15-нд ихэнх нутгаар 0,0-3,0 мм, 17,18-нд зарим газраар 0,0-0,3 мм бороо, нойтон цас, 22-нд Жаргалантад 0,2 мм, 30-ны шөнө нутгийн баруун өмнөд болон зүүн хойд хэсгээр 1,0-7,0 мм, 30-ны өдөр нийт нутгаар 0,0-7,0 мм бороо оров.

Сарын нийлбэр тунадас 4,0-21,8 мм байна. Хамгийн их нь Эрдэнэсантад 21,8 мм, харин Баян-Өнжүүлд 4,0 мм буюу бага тунадас оржээ. Цасны зузаан өртөө харуулуудын талбай дээрх хэмжилтээр 3,4-ний өдрүүдэд цасны зузаан өртөө харуулын талбай дээрх хэмжилтээр 2-51 см, хамгийн их нь Эрдэнэсантад 51 см болсон ба 7-8 хоногийн дотор хайлж, 16-ны өдөр цасан бүрхүүлгүй болсон байна. 15-ны шөнө ихэнх нутгаар 0,0-3,0 мм цас орж, цасны зузаан 0-4 см болж, хоногтоо хайлсан. Бусад хугацаандаа нийт нутгаар цасан бүрхүүлгүй байв. 3-4-нд шилжих шөнө, 4-ний өдрийн

цас, цасан шуурга нь гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрсэн. 14-ний өдөр зарим газраар хүчтэй салхи, 15-ны шөнө ихэнх нутгаар цас орж шуурсан нь цаг агаарын аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна.

Салхи ихэнх өдрүүдэд 6-11 м/с, зарим өдрүүдэд 16-18 м/с, түр зуур 20 м/с, 4-ний өдөр зарим газраар 24-28 м/с хүрч ширүүсэв.

Сарын эхний 10 хоногтоо нийт нутгаар хүйтэн байсан ба 4-6-нд өмнөх хоногуудаасаа хүйтэрч шөнөдөө 16-27 градус, өдөртөө 2-9 градус хүйтэн, бусад ихэнх хугацаанд шөнөдөө 4-12 градус хүйтэн, өдөртөө 10-16 градус дулаан, 13,14,23-25-нд нилээд дулаарч өдөртөө ихэнх нутгаар 19-26 градус дулаан, 28-нд зарим газраар 30 градус хүрч дулаарав.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

- агаарын дундаж температур нийт нутгаар 2-3 градус орчмоор хүйтэн

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь +26+30 градус дулаан, ихэнх нутгаар 2-5 градусаар дулаан, Батсүмбэр, Бачнцагаан орчмоор 2 градусаар хүйтэн ажиглагдсан байв.

- шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн хүйтэн температур нь 16-27 градус хүйтэн, Баянцагаан, Заамарт 16 градус хүйтэн, Мааньтад 27 градус хүйтэн буюу нийт нутгаар 8-17 градус орчмоор хүйтэн ажиглагдсан.

- Сарын нийлбэр тунадас 4,0-21,8 мм байна. Хамгийн их нь Эрдэнэсантад 21,8 мм, харин Баян-Өнжүүлд 4,0 мм буюу бага тунадас оржээ. Тунадасны хувьд өмнөх оныхоос нутгийн зүүн хэсэг болон газар тариалангийн бүс нутгийн зарим газраар өмнөх оны мөн үеэс ахиу тунадас орсон

сарынхаа эхээр болон ихэнх хугацаандаа сэрүүвтэр, цаг агаартогтворгүй, салхи шуурга ихтэй сар байлаа.

#### 2015ОНЫ ТАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

*Төв аймгийн нутгаар.* Агаарын температурын сарын дундаж нь Төв аймгийн зүүн хэсгээр 4-9 градус, бусад хэсгээр 10-15 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна.

Сэрүүсэх үе Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхний хагаст сэрүүсч Туул голын хөндийгөөр шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 4-9 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 9-14 градус дулаан байна. Гуравдугаар арав хоногийн дунд үеэр бага зэрэг сэрүүсч ихэнх нутгаар шөнөдөө 2 градус дулаанаас 3 градус хүйтэн, өдөртөө 12-17 градус дулаан байна. Дулаарах үе Гуравдугаар арав хоногийн эхээр голын хөндийгөөр шөнөдөө 7-12 градус, өдөртөө 25-30 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 4-9 градус, өдөртөө 20-25 градус хүрч дулаарна.

Бусад хугацаанд Уулархаг нутгаар шөнөдөө 4 градус хүйтнээс 1 градус дулаан, өдөртөө 10-15 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус, өдөртөө 16-21 градус дулаан, голын хөндийгөөр 20-25 градус дулаан байх төлөвтэй.

Энэ сард Төв аймгийн зүүн өмнөд хэсгээр олон жилийн дунджаас бага, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас байх төлөвтэй.

Нэгдүгээр арав хоногийн эхэн болон дунд үе, хоёрдугаар арав хоногийн эхний хагаст ихэнх нутгаар хур тунадас,

уулархаг нутгаар нойтон цас орно. Хоёр ба гуравдугаар арав хоногийн сүүлчээр зарим газраар, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар бороо, уулархаг нутгаар хур тунадас орох төлөвтэй. Дуу цахилгаантай.

Дээрх үеүдэд салхи нутгийн өмнөд хэсгээр 12-14 м/с, ялангуяа нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим үед 16-18 м/с хүртэл ширүүсч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.

#### ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

5 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим, Алтайн уулархаг нутаг, Алтайн өвөр говь, Их нууруудын хотгороор олон жилийн дунджаас дулаан, хур тунадас ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим ба түүнээс ахиу, харин Алтайн өвөр говь, Галба, Өөш, Долоодын говиор дунджаас бага орох төлөвтэй байна.

5 дугаар сард ихэнх нутгаар хүйтэн хавсаргатай, ялангуяа тал хээр, говийн нутгаар үе үе хүчтэй шороон шуурга шуурч, бэлчээрийн ургамлын ургалтыг удаашруулахын зэрэгцээ малын хариулга, маллагаанд таагүй нөлөөлөх төлөвтэйг онцгой анхаарна уу.

#### 2015 ОНЫ ЗУРГААДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Агаарын температурын сарын дундаж нь ихэнх нутгаар 15-20 градус дулаан буюу олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим орох төлөвтэй.

## Гол мөрний усны түвшин ба урсацын урьдчилсан мэдээ

5 дугаар сард Хөвсгөлийн уулсаас эх авсан Дэлгэрмөрөн, Эг, Бэлтэс, Бүгсий зэрэг голууд болон Хэнтэй нурууны баруун хажуугаас усжих Хараа, Ерөө, Туул, Тэрэлж голуудын усны түвшин олон жилийн дунджаас 10-40 см бага, мөн Хангай нурууны араас эх авсан Чулуут, Идэр, Суман голуудын усны түвшин олон жилийн дунджаас 20-50 см бага байх төлөвтэй байна.

Ихэнх гол мөрний усны түвшин олон жилийн дунджаас бага ба түүний орчим байх төлөвтэй байгаа хэдий ч Алтай нуруунаас усжих Булган, Сагсай, Турган голуудын усны түвшин олон жилийн дунджаас 10-20 см ахиу байх ба 5 дугаар сарын дунд үеэр зарим томоохон голын усны түвшин өмнөх өдрийнхөөс 10-30 см нэмэгдэх төлөвтэй

Манай орны гол мөрний хаврын шар усны үерийн оргил үе гол төлөв 5 дугаар сарын эхэн ба дунд үеэр ажиглагддаг боловч энэ жилийн хувьд онцгой үер ажиглагдахгүй төлөвтэй.

Зарим томоохон гол мөрний 5 дугаар сард ажиглагдах усны түвшин болон урсацын хэмжээг олон жилийн дундажтай харьцуулан 1 дүгээр хүснэгтэд үзүүлэв.




### 1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2015 оны эхний 4 сард аймгийн хэмжээнд 330 гэмт хэрэг бүртгэгдэж 311 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 1048.7 сая₮-ийн хохирол учирлаа.

Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар



Гарсан гэмт хэргийн 39.88 хувь нь хулгай, 26.19 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний -ний хэрэг, 11.31 хувь нь бусад хэрэг. 16.67 хувь нь замын осол, 4.76 хувь нь танхай дээрэм, 1.19 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Баяндэлгэр, Заамар, Батсүмбэр, Борнуур сумдад 10000 хүнд 196-92 гэмт хэрэгнэгдсэн нь аймгийн дунджаас (37)-аас харьцангуйих байна.

Гэмт хэргийн тоо 2014 оны мөн үеэс 6 хэргээр буурлаа.


Зуунмод суманд 19 эмэгтэй, 371 эрэгтэй нийт 390 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2014 оны мөн үеэс 28хүнээр буурлаа.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр.



### Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2015 оны эхний 4 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 339 гүйцэтгэх хуудсанд нийт 1.42 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 13 гүйцэтгэх хуудсанд ногдох 461.5 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 326 гүйцэтгэх хуудасны 962.0 сая ₮-өөс 123 хуудасны 280.0 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 37.73 хувь, үнийн дүнгээр 29.11 хувь болж 2014 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 13.4 нэгжээр өсч, үнийн дүнгийн биелэлт 11.81 нэгжээр буурлаа.



## II. Эдийн засгийн үзүүлэлт



### II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2015 оны эхний 4 сард кассын орлого 119.3 тэрбум₮, кассын зарлага 116.8 тэрбум₮ болж, гүйлгээнд 1.4тэрбум₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 2015 оны эхний 4 сарын байдлаар 117.0 тэрбум₮, байгаа нь өмнөх оны эцсээс 1.6 тэрбум₮-өөр буурлаа.

2015 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 44.0 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Иргэдийн хувийн хадгаламжинд 4 сарын 30-ний байдлаар 41.0 тэрбум₮ байна.

Харилцах дансны үлдэгдэл 4 сарын 30-ны байдлаар 257739 иргэний 9.7 тэрбум₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.34-1.37 хувь, хугацаатай доод хүү 0.65-0.91 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



### II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2015 оны эхний 4 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 2.5 тэрбум ₮, зарлага 19.9 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 89.75 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Урсгал орлого,

татварын орлого, хувь хүний орлогын албан татвар, бусад албан татвар, төлбөр, хураамж, улсын тэмдэгтийн хураамж, газрын төлбөр, ойгоос түлээ, мод ашигласны төлбөр, нохойн албан татвар, хүү торгуулийн орлого, төрийн өмч худалдсаны орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2014 оны мөн үеэс 21.39 хувь буюу 690.7 сая ₮-өөр буурлаа. Аймгийн төсвийн орлогын 79.11 хувийг татварын, 20.48 хувийг татварын бус, 0.42 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2014 оны мөн үеэс татварын орлого 4.1 нэгжээр буурч, татварын бус орлого 4.7 нэгжээр өсч, хөрөнгө борлуулсны орлого 0.5 нэгжээр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 3257.6 сая ₮ болж аймгийнх 2081.8 сая ₮ буюу 63.91 хувь, сумынх 456.1 сая ₮ буюу 14.00 хувь, улсынх 719.7 сая ₮ буюу 22.09 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2014 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 23.46 хувь буюу 185.2 сая ₮-өөр өсч 974.6 сая ₮ болж, авлага 74.47 хувь буюу 67.2 сая ₮-өөр өсч 157.4 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 2.7 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 103.89 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 456.0 сая ₮ болж, төлөвлөгөө 138.34 хувь биелж, Борнуур, Батсүмбэр, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл, Аргалант, Баянхангай, Лүн, Зуунмод, Баянчандмань сумд 34.11-0.48 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 2081.7 сая ₮ болж 83.33 хувь биелж Өндөрширээт, Сэргэлэн, Заамар, Баян-Өнжүүл, Баянхангай, Архуст, Цээл, Эрдэнэ, Батсүмбэр, Бүрэн, Баянцагаан, Мөнгөнморьт, Алтанбулаг, Борнуур, Жаргалант, Лүн,

Аргалант, Сүмбэр, Дэлгэрхаан, Баян сумд төлөвлөгөө 52.83-2.31 хувиар тасалдууллаа.



### II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2015 оны 4-р сард хэрэглээний үнийн индекс суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 56.93%, өмнөх оны мөн үеэс 7.56%, өмнөх сараас 1.43 хувиар тус тус өсөв.

Бараа, үйлчилгээний бүлэг	2015 оны 4 сард	
	пунктээр	хувиар
<b>Бүгд</b>	1.43	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.77	54.30%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.28%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.37	26.05%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.09	6.42%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.10	7.16%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.03	1.86%
07. ТЭЭВЭР	0.03	2.24%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.01	0.91%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.01	0.78%

Хэрэглээний үнийн индексийн 2015 оны 4 дүгээр сарын 1.43 хувийн өсөлтийн 0,77 нэгж (54.30%) нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн; 0,37 нэгж (26.05%) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн; 0,10 нэгж (7.16%) нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн; 0,09 нэгж (6.42%) нь орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнийн өсөлтөөс тус тус шалтгаалжээ.

Зураг II.4

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)





## II.4 Хөдөө аж ахуй

### Төл бойжилт

5 сарын 1-ний байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 67.9 хувь 1272.8 мянган хээлтэгч мал төллөж, 1279.2 мянган төл гарсны 97.4 хувь 1245.7 мянган төл бойжиж байгаа нь урьд оны мөн үеэс төллөсөн хээлтэгч 9.8 хувь буюу 125.2 мянгаар; бойжиж буй төл 7.7 хувь 96.0 мянгаар тус бүр өслөө.

Оны эхний төллөх насны ингэний 38.1; гүүний 32.2; үнээний 41.1; эм хонины 71.9; эм ямааны 72.2 хувь нь тус бүр төллөв.



Гарсан төлийн 2.6 хувь 33526 болох толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 3.9 дахин буюу 26684 төлөөр өслөө. Гарсан унаганы 1.0, тугалын 2.1, хурганы 2.1, ишигний 3.5 хувь нь тус бүр хорогдов. Борнуур, Баянчандмань, Сүмбэр, Эрдэнэсант, Заамар сумд гарсан төлийнхөө 16.1-4.9 хувь буюу 6553-891 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 27.9 хувийг (бүгд 19305 төл) эзлэв.

Бойжуулсан төлийн тоо, төрлөөр, аймгийн дүнгээр

	мян.тол				
	2011	2012	2013	2014	2015
Бүгд	862.0	907.1	927.3	1149.6	1245.7
Ботго	0.2	0.3	0.3	0.3	0.4
Унага	12.0	16.8	16.4	28.0	32.4
Тугал	15.2	34.0	26.5	41.1	47.5
Хурга	479.3	497.4	531.9	644.2	708.3
Ишиг	355.3	358.7	352.2	436.0	457.1

### Том малын зүй бус хорогдол


5 сарын 1-ний байдлаар оны эхний малын 0.7 хувь буюу 27437 том мал зүй бусаар хорогдсон нь 2014 оны мөн үеэс 3.3 дахин буюу 21146 толгойгоор өслөө. Хамгийн их хорогдолтой 5 сум Эрдэнэсант, Борнуур, Заамар, Сүмбэр, Лүн сумд оны эхний малынхаа 2.6-1.1 хувь буюу 10071-470 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 67.4 хувь (бүгд 18515) эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо эхний 4 сард төрлөөр, аймгийн дүнгээр /толгой/

	2011	2012	2013	2014	2015
Бүгд	8488	11241	19779	6291	27437
Тэмээ	2	1	4	6	4
Адуу	611	874	857	560	1064
Үхэр	685	1001	1133	544	1447
Хонь	3550	4550	8355	2582	12677
Ямаа	3640	4815	9430	2599	12245

Оны эхний тэмээний 0.1, адууны 0.3; үхрийн 0.5; хонины 0.6; ямааны 0.9 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 1.6 хувь нь өвчнөөр, 26.9 хувь нь хээлтэгч мал эзлэв.

Зүй бусаар хорогдсон том малын тоо, эхний 4 сард



## II.5 Аж үйлдвэр

2015 оны эхний 4 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 4.05 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2014 оны мөн үеэс 81.4 хувь буюу 1819.5 сая ₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Жаргалант, Зуунмод, Баянцогт, Баянцагаан, Батсүмбэр, Борнуур, Баянчандмань, Эрдэнэ, Угтаалцайдам, Архуст, Өндөрширээт сумд 37.44-1.26 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 91.42) хувийг эзлэв.

Зураг II.9

### Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр


АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, мян.төг  
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2014 IY	2015 IY	2014 I-IY	2015 I-IY	Дүнд захзаш % Percentage share to total		2015% 2014%
					2014 I-IY	2015 I-IY	
Нийт дүн	759.20	2,140.46	2,234.59	4,054.09	100.0	100.0	181.4%
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	168.04	1,691.29	394.91	1,762.54	17.67%	43.48	446.3%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	369.12	255.14	907.63	1,372.50	40.62	33.85	151.2%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	222.04	194.04	932.06	919.05	41.7	22.67	98.6%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, архи, ундаа үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл өмнөх оноос 2825.2-0.3 хувь буюу 160.41-0.12 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Зураг II.10

### Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 4 сарын нийт үйлдвэрлэлтэд дулааны эрчим хүч 22.67, боловсруулах үйлдвэрлэл 33.85, ашигт малтмал олборлолт 43.48 хувийг тус тус эзлэв.

Зураг II.11

### Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, хувиар



## II.6 Барилга


Зураг II.12

Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2015 оны эхний

4 сард 436.0 сая ₮-ийн их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2014 оны мөн үетэй харьцуулахад 46.53хувь буюу 379,4 сая ₮-өөр буурав.

Барилга угсралт, их засварын ажлын 88.53 хувь нь инженерийн барилга байгууламжид; 11.47 хувь нь орон сууцны бус барилгад ногдож байна. Энэ нь 2014оны мөн үетэй харьцуулахад орон сууцны бус барилгын ажил 52.68 пунктээр буурч, инженерийн барилга байгууламжийн ажил 52.68 пунктээр өссөн үзүүлэлт юм.

**Барилгын ажлын гүйцэтгэл, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр**




## II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 4 сард 66.7 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 30.6 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14.48 хувь буюу 11.3 сая ₮-өөр буурлаа.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 29.3 сая ₮ болж, нийт орлогын 74.4 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 25.2 хувийг албан бичгийн, 13.3 хувийг зорчигчдын, 61.48 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10

**Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 4 дүгээр сарын байдлаар, сая төгрөгөөр**



## Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2015 оны эхний 4 сард нийт 693 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 34; төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны баталгаажуулалт 1; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 201; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 3; бэлэглэлийн гэрээ 35; худалдах, худалдан авах гэрээ 33; өв залгамжлал 6; барьцааны гэрээ 262; бусад бүртгэл 118 тус бүр бүртгүүлээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2015 оны эхний 4 сард нийт 86 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ 60; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 10; үйлдвэрчний эвлэлийн байгууллага /ҮЭБ/ 8; гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 3; Хоршоо 3; бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл /ББН/1; төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар /ТБАГУТҮГ/ 1 тус бүр бүртгүүлээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2015 оны 4 сарын мэдээгээр 159 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 28; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 45; данс нэмэгдсэн, хасагдсан 15; дүрэм шинэчилсэн 4; дахин гэрчилгээ 17; удирдлага өөрчлөгдсөн 7; үйл

ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 13; дүрмийн сан нэмэгдсэн 5; нэгдсэн 1; хаяг өөрчлөгдсөн 10; татан буугдсан 12; нэр өөрчлөгдсөн 1; салбар бүртгүүлсэн 1 тус бүр бүртгүүллээ.

### **Стандартчилал хэмжилзүй**

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2015 оны эхний 4 сарын мэдээгээр нийт 60 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 268; үүнээс тохирлын гэрчилгээ 203, дотоодын бүтээгдэхүүний баталгаажуулалт 65; цулын хэмжүүр 341, үүнээс жин 263, туухай 77, автомашины жин 1; эзлэхүүний хэмжүүр 55, үүнээс түгээгүүрийн хошуу 45, сүмбэн метр 7, усны тоолуур 3; цахилгааны хэмжүүр 259, үүнээс нэг фазын тоолуур 254, гурван фазын тоолуур 5 тус бүр баталгаажуулсан байна.